



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 525

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2021 он, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 6,213,893,690.00 (зургаан тэрбум хоёр зуун арван гурван сая найман зуун ерэн гурван мянга зургаан зуун ер) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.“Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай.

2.1.Компанийн батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэн, тухайн оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах;

2.2.“Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах.

2.3.Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлд орсон нэмэлт өөрчлөлтийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр тухай бүр компанийн дүрэмд оруулж байх;

3.“Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирал (Б.Эрдэнэбулган)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай;

3.1.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах;

3.2.Компанийн эзэмшилд байгаа 6 газрын эзэмших, ашиглах эрхийг, санхүүгийн тайланд бүртгэлтэй 171.0 м.кв-ийн зөрүүтэй 4 газрын талбайн хэмжээг Сангийн сайдын баталсан аргачлалын дагуу тус тус үнэлж бүртгэх;

3.3.Монгол Банкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг үндэслэн арилжааны банкийг сонгон шалгаруулж компанийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг байршуулах, эрсдэлийг тогтмол хянаж ажиллах;

3.4.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам” -ыг мөрдлөг болгон ажиллах, зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, төрийн өөрийн өмчид бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

3.5.Худалдан авах ажиллагааг хууль тогтоомж болон бусад холбогдох журмаар батлагдсан маягтын дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тайланг, иж бүрэн үнэн зөвөөр тайлагнан мөрдөж ажиллах;

3.6.Нягтлан бодох бүртгэлийн тухай 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэг “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно “-ийг болон бусад хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;

3.7.Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.1.2-т заасан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдал”-д дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийж байх;

3.8.Компанийн тайланд тусгагдаж, олон жил болсон шүүхийн шатанд маргаантай байгаа авлагууд болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа авлагуудыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх, хөрөнгийг битүүмжлэх.

4.Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний хэрэгжилтэд Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтэд Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ) хяналт тавьж ажиллахыг тус тус даалгасугай.

5.Тогтоолын биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

6.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн
22 дугаар тогтоолын хавсралт



**“ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ” ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ ДУТАГДАЛ ТҮҮНИЙГ
АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Дүн (мян.төг)	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ	
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлээгүй бараа материал, ажил үйлчилгээ	410,565.10	Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах	
2	Үндсэн баримтгүй бүрдэл дутуу	Тушаал шийдвэргүй	6,009.80	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Мөнгөн кассын үйл ажиллагааны журам”-ыг хуулийг мөрдөж ажиллах
		Гэрээгүй	23,109.55	
		Техникийн комиссын шийдвэргүй машин засвар	4,138.40	
		Эрх бүхий байгууллагын шийдвэргүй гадаад томилолтын зардал	8,361.04	
		Хаалгаагүй томилолтын хуудсаар олгосон томилолтын зардал	5,058.00	
3	Сонгон шалгаруулалт хийхгүйгээр арилжааны банкуудад байршуулсан мөнгөн хөрөнгө	5,155,089.00	Сонгон шалгаруулалт явуулах. ТӨБЗГ-ын зөвлөмжийг мөрдөж ажиллах	
4	Хууль, тогтоомж зөрчин олгосон үргүй зардал	40,988.00	Төсвийн хууль, ТӨБЗГ-тай байгуулсан контрактын гэрээг мөрдөж ажиллах	
5	Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй өр, авлага	215,541.90	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах	
6	Хууль тогтоомж зөрчин гаргасан үргүй зардал	40,988.00	Төсвийн хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах,	
7	Эрх бүхий байгууллагын шийдвэргүй балансаас хассан орон сууцны барилга	304,044.90	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөж ажиллах,	
Нийт дүн		6,213,893.69	(зургаан тэрбум хоёр зуун арван гурван сая найман зуун ерэн гурван мянга жаран есөн төгрөг)	